

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ 07 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН


2026 оны 08 дугаар сарын 06

Улаанбаатар хот

Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 07 дугаар сарын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын 30 арга хэмжээ бүрэн хангалттай буюу 90-100 хувь үнэлэгдсэн байна. Үүнээс 85 хувьтай 23 арга хэмжээ буюу 76.6 хувь, 7 арга хэмжээ буюу 23.3 хувь нь 100 хувьтай үнэлэгдлээ. (График1)

График 1



Дээрхээс зорилт тус бүрийн үнэлгээ нь нэгдүгээр зорилтод байгууллагын үндсэн үйл ажиллагаа буюу гадаадын иргэнд холбогдох зөвшөөрөл, бүртгэл, хяналт, иргэний харьяалал, зөвлөгөө, мэдээллийн чиглэлээр 4 газар, нэгжийн 7 үйл ажиллагааг төлөвлөсөн нь 85 хувийн, хоёрдугаар зорилтоор нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр 5, газар нэгжийн 23 арга хэмжээний дундаж нь 89.5 хувь үнэлэгдсэн байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Д/д	Зорилт	Нийт арга хэмжээ	85%-иас дээш	70-85% хүртэл	70% хүртэл	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7

1	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	7	-	-	-	85.0
2	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	23	8	15	-	89.5
Нийт		30	7	16	0	87.3

Нэгж тус бүрээр төлөвлөн гүйцэтгэсэн арга хэмжээний дундаж үнэлгээгээр авч үзвэл зорилтод түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарч бүх газар, хэлтэс оновчтой тодорхойлж 85 хувиас дээш үнэлэгдсэн байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	85%-иас дээш	70-85% хүртэл	70% хүртэл	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7
1	Захиргаа, удирдлагын газар	12	1	11	-	86.2
2	Виз, зөвшөөрлийн газар	2	-	2	-	85
3	Иргэний харьяаллын газар	1	-	1	-	85
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	-	3	-	85
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	3	2	1	-	95
6	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	2	2	-	-	100
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ аудитын хэлтэс	3	1	2	-	90
8	Мэдээллийн технологийн хэлтэс	1	1	-	-	100
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	1	-	1	-	85
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс	1	-	1	-	85
11	Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс	1	-	1	-	85
Нийт		30	7	23	-	89

Мөн газар хэлтсүүдийн буюу Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс болон Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан тус бүр нэг нэг арга хэмжээ 85 хувь үнэлэгдсэн байна.

Дүгнэлт

Байгууллагын 2026 оны 07 дугаар сард төлөвлөн гүйцэтгэсэн 30 арга хэмжээний хэрэгжилт 87.3 хувьтай үнэлэгдлээ. Энэ нь өмнөх сартай харьцуулбал 2.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

“Хангалттай” буюу 85 хүртэл хувьтай 23 арга хэмжээний үр дүнг цаашид нэмэгдүүлж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

Онцлох ажил: Визийн шаардлагаас чөлөөлөх тухай Засгийн газар хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийг эмхэтгэсэн гарын авлага болон Цагаачлал, шилжилт хөдөлгөөний салбарт нийтлэг хэрэглэгддэг англи хэлний үгсийн жагсаалт зэргийг албан хэрэгцээнд ашиглах зорилгоор “erp” системд нийтэлж, албан хаагчдад өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэх боломжийг бүрдүүлсэн байна.

--oo0oo--